



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 11 өдөр

Дугаар A/405

Арвайхээр

**Тэмцээн зохион байгуулах, ажлын
хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ–2020” хөтөлбөрийн 3.3.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Таеквондогийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг Арвайхээр хотноо 2019 оны 6 дугаар сарын 22-ноос 23-нд зохион байгуулж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Тэмцээний бэлтгэл, зохион байгуулалт, аюулгүй байдлыг сайтар ханган ажиллахыг ажлын хэсэг (О.Батжаргал)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100664

Аймгийн Засаг даргын 2019 оны 06
дүгээр сарын 11-ны өдрийн 11/05 дугаар
захирамжийн хавсралт



**ТАЕКВОНДОГИЙН ӨСВӨР ҮЕИЙН УЛСЫН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн дарга: О.Батжаргал – Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга: Б.Энхтөр – Аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн
тамир, спортын газрын дарга
- Гишүүд: О.Ганбат – Цагдаагийн газрын дарга
Ж.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл,
урлагийн газрын дарга
Ж.Энх-Амар - Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын дарга
Г.Мөнхтөр – Аймгийн Засаг даргын дэргэдэх Стандартчилал,
хэмжил зүйн хэлтсийн дарга
Д.Түмэнжаргал – Аймгийн Хөгжимт, драмын театрын дарга
О.Пүрэвдорж – Арвайхээр сумын Засаг дарга
Д.Ганбаатар – Өвөрхангай аймгийн Таеквондогийн холбооны
ерөнхийлөгч /зөвшилцсөнөөр/

-оОо-